



СЭЛЭНГЭ АЙМАГ
ОРХОНТУУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/95

Баянцогт

Хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааны
ажлын төлөвлөгөө, захиргааны шийдвэр
хянах, хуваарь батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хууль тогтоомжийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3, Засгийн газрын 2018 оны "Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай" 50 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны "Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр" батлах тухай 154 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/304 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын А/304 дүгээр захирамжийн 1 дүгээр хавсралтад заасан хуваарийн дагуу 2023 оны 4 дүгээр улиралд захиргааны шийдвэрийг хянуулахыг Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэнд үүрэг болгосугай.

2. Сумын хэмжээнд зохион байгуулах Хууль эрх зүйн сургалт, сурталчилгааны хуваарийг 1 дүгээр, "Эрх зүйн хөтөч"-ийн хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааны сэдэв, хуваарийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Хууль тогтоомжийн сургалт, сурталчилгааны ажлыг цахим болон танхимын хэлбэрээр үр дүнтэй зохион байгуулж, зохион байгуулсан сургалтын тайланг Хууль, эрх зүйн мэргэжилтэнд тухай бүрт өгч ажиллахыг Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэнгүүд, төсвийн байгууллагын дарга, эрхлэгч нарт, мэдээ, мэдээллийг цахим хөтөч (e-khutuch.mn)-д тогтмол байршуулж ажиллахыг Хууль, эрх зүйн мэргэжилтэнд үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын түр орлон гүйцэтгэгч (Д.Саруулбаясах)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ П.ОТГОНБАЯР



D:\my doc\bichig hereg\захирамж 2023.docx

Сумын Засаг даргын 2023 оны... Д.Л... дугаар сарын 19-ийн... дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОНТУУЛ СУМЫН ХУУЛЬ
ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Сурталчлах хуулиуд	Хугацаа	Зохион байгуулагч	Хамтран хэрэгжүүлэгч
1	<p>Нийтлэг сурталчлах хуулиуд</p> <ul style="list-style-type: none"> ▪ Монгол улсын Үндсэн хууль ▪ Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль ▪ Захиргааны ерөнхий хууль ▪ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль ▪ Нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль ▪ Төрийн албаны тухай хууль ▪ Хөдөлмөрийн тухай хууль ▪ Авлигын эсрэг хууль ▪ Төсвийн тухай хууль ▪ Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль ▪ Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль ▪ Зөрчлийн тухай хууль ▪ Зөвшөөрлийн тухай хууль ▪ Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль ▪ Гэмт, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль ▪ Гамшгаас хамгаалах тухай хууль 	Жилдээ	Төрийн захиргаа, хууль эрх зүй, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн	ЗДТГ-ын мэргэжилтэнгүүд, Эрүүл мэндийн төв

	<ul style="list-style-type: none"> ▪ Төрийн албан хаагчийн ёс, сахилга хариуцлагын тухай ▪ Эрүүл ахуйн тухай хууль <p>Дээрх хуулиуд болон холбогдох дүрэм, журам, тогтоол, шийдвэрүүд</p>			
Зохион байгуулах сургалтын сэдэв, хуваарь				
1	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор нөлөөний талаарх сургалт, сурталчилгааг зохион байгуулах	Жилдээ	Цагдаагийн хэсэг	Сумын ИТХ-ын ажлын алба, ЗДТГ-ын Хууль, эрх зүйн мэргэжилтэн, Нийгмийн бодлогын мэргэжилтэн, багийн Засаг дарга нар
2	Байгалийн аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх нь болон экологийн аюулгүй байдлын талаарх сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах	Жилдээ	Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн, Орхон бүсийн сум дундын ойн анги, Байгаль хамгаалагч нар	Цаг уурч, Ойн нөхөрлөл, аж ахуйн нэгжүүд
3	Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх арга зүй, ажил мэргэжлийн баримжаа олгох сургалт болон багшийн ёс зүйн талаарх сургалт сурталчилгааг зохион байгуулах	Жилдээ	Ерөнхий боловсролын сургууль, 1 дүгээр цэцэрлэг	Хууль, эрх зүйн мэргэжилтэн
4	Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, буцаан олголтын талаар болон аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын тайлан, хөнгөлөлт, чөлөөлт, буцаан олголтын талаарх сургалт сурталчилгааг зохион байгуулах	Жилдээ	Татвар хураагч	Хууль, эрх зүйн мэргэжилтэн

	хуулиудаар сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах				
10	Салбарын хуулиудаар болон газрын харилцааны өргөдөл бүртгэлийн материал бүрдүүлэлтийн талаарх, мэдээ мэдээлэл сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах	Жилдээ	Газрын даамал	Хууль эрх зүйн мэргэжилтэн	
11	Мал сүргийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын хашаа хороо, өвөлжөө, хаваржаа, уст цэгийн ариутгал халдваргүйтгэлийн талаарх сургалт сурталчилгааг зохион байгуулах Малын генетик нөөцийн тухай хууль, малын үзлэг ангилалт бүртгэлжүүлэлтийн талаарх сургалт сурталчилгааг зохион байгуулах	Жилдээ	ХАА-н тасаг, Мал эмнэлгийн тасаг	Хууль эрх зүйн мэргэжилтэн	
12	Улсын бүртгэлийн ерөнхий хууль болон тоон гарын үсэгний талаар иргэдэд олон нийтэд мэдээлэл түгээх, сургалт сурталчилгааг зохион байгуулах	Жилдээ	Улсын бүртгэгч	Хууль эрх зүйн мэргэжилтэн	
13	Эрүүл мэндийн тухай, Эрүүл ахуйн тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай, Донорын тухай хуулиудаар сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах	Жилдээ	Эрүүл мэндийн төв	Хууль эрх зүйн мэргэжилтэн, Нийгмийн даатгалын байцаагч	
14	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Нууцын тухай хуулиар сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах	Жилдээ	Хууль, эрх зүйн мэргэжилтэн	Төр, төсвийн байгууллагууд	
15	Эрүүл мэндийн даатгалын тухай хууль /даатгалтай холбоотой болон иргэдэд хэрэгтэй мэдээллийн талаар судалж, хууль эрх зүйн сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах/	Жилдээ	Нийгмийн даатгалын байцаагч	Хууль, эрх зүйн мэргэжилтэн	
16	Соёлын тухай хууль /иргэдэд хэрэгтэй мэдээллийн талаар судалж, хууль эрх зүйн сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах/	Жилдээ	Соёлын төв	Хууль, эрх зүйн мэргэжилтэн	